



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 33

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Түүх угсаатны музейн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музей нь БСШУЯ-наас хөрөнгө оруулалтаар ирсэн 3389890 төгрөгний тоног төхөөрөмжийг орлогод бүртгээгүй, санхүүгийн тайлангийн бараа материалын тайлан, няравын бараа материалын тайлангийн орлого нь 18587203 төгрөг, зарлага нь 9733091,54 төгрөгөөр зүрүүтэй, нярав нь түлш, шатах тослох материалын тайлан гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4. "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна. 14.4.1." аж ахуйн бүх ажил, гүйлгээ" 14.4.2. "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" заавал бүртгэнэ гэсэн заалтыг зөрчсөн байна.


Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дугаар зүйлийн 4.1.7 дахь "Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан

зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. БСШУЯ-аас хөрөнгө оруулалтаар ирсэн 3389890 төгрөгийн тоног төхөөрөмжийг 2018 оны 01 дүгээр улиралд багтаан орлогод авах.

2. 2017 оны түлш, шатах тослох материалын тайланг нөхөн гаргуулах

3. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 05 дугаар сарын 05-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн түүх угсаатны зүйн музейн төсвийн захирагч А.Мандах, Б.Намсрай нарт хариуцуулав.



АЛБАН ШААРДЛАГЫГ



¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага